


БАТЛАВ: ШУТИС-ИЙН ЭЛСЭЛТИЙН ТӨВ КОМИССЫН ДАРГА Х.ЭНХЖАРГАЛ



**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
АХЛАХ СУРГУУЛЬД 2019-2020 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД
СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 333 дугаар тушаалын хавсралт “Ерөнхий боловсролын сургуульд гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт зохион байгуулах үлгэрчилсэн журам” –ын 3.3 дахь заалт, шинжлэх ухаан технологийн их сургуулийн ахлах сургуулийн (сургалтын) үйл ажиллагааг зохицуулах журмын 6.1, 6.2 дахь заалтыг тус тус баримтлан ШУТИС-ийн ахлах сургуульд 2019-2020 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2 ШУТИС-ийн ахлах сургуульд элсэн суралцахаар хүсэлт гаргагчийн элсэлтийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.3 Сургуулийн материаллаг бааз, анги кабинетын хүрэлцээ зэргээс хамааран шинээр элсэх суралцагчдын тоог захирлын зөвлөлийн шийдвэрээр тогтооно.
- 1.4 Элсэлтийг 10-р ангид зохион байгуулна.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН КОМИСС БАЙГУУЛАХ

- 2.1 ШУТИС-ийн ахлах сургуулийн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах салбар комиссын бүрэлдэхүүн, гишүүдийн ажил үүргийн хуваарийг ахлах сургуулийн захирлын тушаалаар батална.
- 2.2 Элсэлтийн комисс нь энэхүү журмыг баримтлан элсэлтийн шалгалтыг зохион байгуулах, элсэгчдийн материалыг шалгах, өргөдөл гомдлыг барагдуулах, элсэлтийн явцад хяналт тавих болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулна.
- 2.3 Бүртгэлийн хураамжийг элсэлтийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагааны зардалд зарцуулна.

ГУРАВ. ЭЛСЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 3.1 Суурь боловсрол эзэмшсэн (80%-иас дээш үнэлгээтэй) байх.
- 3.2 Инженер техник, технологийн болон архитектур дизайн чиглэлээр суралцах сонирхолтой байх.

ДӨРӨВ. ШУТИС-ИЙН АХЛАХ СУРГУУЛЬД ЭЛСЭГЧДИЙГ ШАЛГАЛТАНД БҮРТГЭХ

- 4.1 ШУТИС-ийн ахлах сургуульд элсэгчид нь 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 09:00–18:00 цагийн хооронд ШУТИС-ийн IV байр, ахлах сургуулийн сургалтын албаны 306 тоотод бүртгүүлнэ.
- 4.2 Элсэгч нь дараах материалыг бүрдүүлнэ.

- 4.2.1 Төрсний гэрчилгээ
 - 4.2.2 Хоёр хувь цээж зураг (сүүлийн 6 сарын)
 - 4.2.3 Бүртгүүлэхдээ эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөлтэй ирэх
 - 4.2.4 Бүртгэлийн хураамж
- 4.3 Элсэлтийн шалгалтанд орох бүртгэлийн хуудас олгоно.

ТАВ. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

5.1 Шалгалтын үндсэн зарчим

- 5.1.1 Шалгалтын хугацааг 14-21 хоногийн өмнө олон нийтэд зарлах
- 5.1.2 Шалгалтын даалгавар, шалгуур түвшинд нь тохирсон, үнэн зөв, суралцагчдад ойлгомжтой, бодитой үнэлэлт, дүгнэлт өгөх болон тэдний сэтгэн бодох чадварыг нээн илрүүлэх боломжтой байх
- 5.1.3 Шалгалт шударга, ил тод байх
- 5.1.4 Шалгалт авах хэлбэр нь тодорхой, нийтэд мэдээлэгдсэн байх

5.2 Шалгалтын дэг, шалгалт зохион байгуулах

- 5.2.1 Ахлах сургуулийн элсэлтийн шалгалтыг 2019 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 10:00 цагт зохион байгуулна. Үүнд:
 - Инженерийн бэлтгэл анги – математик (90 мин)
 - Архитектур, дизайны бэлтгэл анги – математик (90 мин), зургийн ур чадварын шалгалт (120 мин) тус тус өгнө.
- 5.2.2 Шалгалтын сэдэв боловсруулах багийг томилох, нууцлалыг хадгалан ажиллах үүргийг шалгалтын комисс хариуцна.
- 5.2.3 Шалгалтын сэдвийг тухайн хичээлүүдийн суурь боловсролын агуулгыг бүрэн багтаасан 3 хувилбартай боловсруулна.
- 5.2.4 Шалгалтын сэдвийг шалгалт авах өдрийн 07:00–09:00 цагийн хооронд сонгон, шалгуулагчдын тоогоор хувилж бэлтгэнэ.
- 5.2.5 Шалгалт авах өдрийн 09:00–10:00 цагийн хооронд комиссын гишүүд шалгуулагчдыг бүртгэлийн хуудастай тулган ангиудад хуваарилан оруулж ассистент багш нарыг томилно.
- 5.2.6 Ассистент багш шалгалтын материалыг тарааж, шалгалтыг эхлүүнэ.
- 5.2.7 Шалгалтын хугацаа дуусмагц ассистент багш шалгуулагчдын материалыг шифрлэж, шалгалтын материалыг хурааж авна.
- 5.2.8 Ассистент багш шалгалтын үеийн үйл ажиллагааны талаар тэмдэглэл хөтөлнө.
- 5.2.9 Шалгалтын явцад шалгуулагчаас зөрчил гарвал (гар утас, ном, дэвтэр, томъёоны хураамж ашиглахыг хориглоно) шалгалтаас шууд чөлөөлнө.

5.3 Шалгалтын материал засах

- 5.3.1 Шалгалт дууссаны дараа томилогдсон багш нар материалыг засаж дүнг шалгалтын хуудсанд засваргүйгээр тэмдэглэн баталгаажуулж шалгалтын комисст хүлээлгэн өгнө.
- 5.3.2 Шалгалтын комисс шифрийг тайлж, онооны дарааллаар нь жагсаан шалгуулагчийн оноог сургуулийн вэбсайт болон мэдээллийн самбарт байрлуулна.

ЗУРГАА. СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ

- 6.1 Ахлах сургуулиас зохион байгуулсан элсэлтийн шалгалтын босго оноог үндэслэн суралцагч элсүүлнэ.
- 6.2 Элсэгч нь 2018-2019 оны хичээлийн жилд математик, физик, дүрслэх урлаг, дизайн технологи, мэдээллийн технологи хичээлүүдээр улс, нийслэлийн хэмжээний олимпиадад 1-5-р байр, бүс, улс, олон улсын хэмжээний чанартай олимпиад, уралдаан тэмцээнд 1-10-р байр эзэлсэн бол амжилтыг харгалзан шалгалтгүйгээр шууд элсүүлнэ.
- 6.3 Төрөлжсөн хичээлүүдийн олимпиадад орж амжилт гаргасан бол амжилтыг гэрчлэх баримт авч ирэх
- 6.4 Элсэлттэй холбоотой аливаа маргааныг элсэлтийн комисс эцэслэн шийдвэрлэнэ.

ДОЛОО. АХЛАХ СУРГУУЛЬД СУРАЛЦАХ ЭЛСЭГЧДИЙГ БҮРТГЭХ

- 7.1 Элсэлтийн комиссийн шийдвэрээр шалгалтанд тэнцсэн элсэгчид нь 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 14-ны өдрүүдэд ахлах сургуулийн хичээлийн байранд бүртгүүлж суралцах эрхийн бичиг авна. Элсэгч нь бүртгүүлэхээр ирэхдээ доорх материалыг бүрдүүлэн авч ирнэ. Үүнд:
 - Сурагчийн хувийн хэрэг (шилжүүлэг хийлгэсэн байх)
 - Суурь боловсролын гэрчилгээ
 - Төлбөр төлсөн баримт
- 7.2 Суралцах эрх авсан боловч заасан хугацаанд ирж бүртгүүлээгүй элсэгчдийг элсэхээс татгалзсан гэж үзэн элсэх эрхийг хүчингүйд тооцно.
- 7.3 Сурагчийн хувийн хэрэг болон, суурь боловсролын гэрчилгээний зөрчилтэй суралцагчдыг элсүүлэхгүй болно.

НАЙМ. НЭМЭЛТ ЭЛСЭЛТ АВАХ

- 8.1 Нэмэлт элсэлтийг 10-р ангид зохион байгуулна.
- 8.2 Нэмэлт элсэлтэнд бүртгүүлэх суралцагчид нь тус журмын 4.2т заасан материалыг бүрдүүлнэ.
- 8.3 Нэмэлт элсэлтийг 2019 оны 08 дугаар сарын 26-наас 2019 оны 08 дугаар сарын 29-ны өдрүүдэд бүртгэж, шалгалтыг 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулна.